



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ КОМПАНИ

2015 оны 03 сарын 16-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

ТЕХНИК ИМПОРТ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Техник импорт ХК-ийн 2015 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 03 сарын 16-ны 09.00 цагт саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 98,8%-ийн ирцтэйгээр Техник импорт ХК-ийн хурлын танхимд хуралдлаа.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Т.Тунгалаг: Сайн байцгаана уу. Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид ээ. Хурлын тооллогын комиссыг ТУЗ-ын хурлаар урьдчилан хэлэлцэж томилсон тул та бүхэнд Тооллогын комиссын бүрэлдэхүүнийг танилцуулья. Тооллогын комиссын даргаар Б. Лхамсүрэн, гишүүнээр Г.Батмөнх нарыг сонгож томилох санал оруулж байна. Ингээд тооллогын комиссыг сонгох санал хураалтыг хувьцаа эзэмшигчдийн дунд явуулья. Зөвшөөрч байгаа хувьцаа эзэмшигчид гараа өргөнө үү. Татгалзсан хүн алга байна.

ХЭХ-д оролцогчдын 100%-ын саналаар Тооллогын комиссыг сонгож баталлаа. Тооллогын комисс хурлын ирцийн талаар танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Б. Лхамсүрэн: Хурлын ирц 98,8 % -тай тоологдсон байна.

ХЭХ-ын дарга Т. Тунгалаг: Тооллогын комиссын мэдээгээр хурлын ирц 50%-иас дээш хувьтай тоологдсон тул компанийн хуульд заасны дагуу энэхүү хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөрт тооцогдож байна. 2015 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхлэхэд бэлэн болж байна. Ингээд хувьцаа эзэмшигч та бүхэнд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулья.

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан түүнд хийсэн аудитын талаар ТУЗ-аас гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн 2015 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
3. Компанийн Аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
4. Компанийн дотоод бүтэц, зохион байгуулалтыг хэлэлцэн батлах
5. Бусад / Ногдол ашиг хуваарилалт, ТУЗ-ын төсөв , цэвэр ашгийн 2%-ийг ажилчдын нийгмийн асуудалд зарцуулахаар олгох/

1. Хурлын ирц бүртгэх	10 минут
2. Хурлын ирц мэдээлэх	3 минут
3. Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулан хувьцаа эзэмшигчдээр хэлэлцүүлэх, санал, шүүмжлэл сонсож санал авах	1 цаг 30 минут
4. Хурлын завсарлага	10 минут
5. Тооллогын комиссын дүн болон тогтоолыг уншиж танилцуулах	10 минут
6. Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	10 минут
7. Хурлын дарга хурлыг хаах	5 минут

ХЭХ-ын дарга Т. Тунгалаг: 2014 онд компаниас хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар Техник импорт ХК-ийн Гүйцэтгэх захирал Д. Ганцэцэг танилцуулна.

Д. Ганцэцэг: Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид ээ.

Та бүхэнд 2014 оны компанийн ХЭХ-аар батлагдсан бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу компанийн удирдлагаас компанийн хэмжээнд зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын биелэлт, үр дүнгийн талаар танилцуулья.

2014 оны ХЭХ-аар батлагдсан бизнес төлөвлөгөөний дагуу компани гадаад худалдааны чиглэлээр ОХУ, Беларусь улсаас гэр ахуйн цахилгаан бараа, БНХАУ болон эх орны үйлдвэр “Хөтөл Цемент Шохой” ХК-иас цемент, цементийн түүхий эд, БНХАУ-ын Шинрэй компаниас мотоцикл болон мотоциклийн сэлбэг хэрэгслийг импортлон борлуулах үйл ажиллагааг эрхлэн явууллаа.

➤ **Гэр ахуйн цахилгаан бараа, сэлбэг хэрэгслэлийг захиалах, борлуулах ажлын хүрээнд дараахь ажлуудыг хийж гүйцэтгэлээ.**

1. 2014 онд компани гэр ахуйн цахилгаан хэрэгслэлийн бүтээгдэхүүнийхээ борлуулалтыг нэмэгдүүлэх, монголын худалдан авагчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэх зорилгоор Беларусь улсын “Атлант” үйлдвэрийн удирдлага болон ажилтнуудтай импортоор нийлүүлэх бүтээгдэхүүний загвар, хийцийг сайжруулах чиглэлээр харилцан санал, бодлоо солилцсоны үр дүнд урьд онуудад компанид нийлүүлж байсан цахилгаан барааныхаа загвар, чанарыг сайжруулан олон жилийн чанарын баталгаатай, техник технологийн дэвшилтэт зүйлийг нэвтрүүлсэн олон үзүүлэлт бүхий тохиргоо, үйлдлийн системтэй гэр ахуйн цахилгаан барааг сэлбэг хэрэгслэлийн хамт компанид нийлүүлснээр шинэ бүтээгдэхүүнийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулж явууллаа. 2014

онд компани захиалгаар нийт 4 удаагийн татан авалтаар шинэ загварын 583 ширхэг хөргөгч, 5 ширхэг хөлдөөгч, 16 ширхэг угаалгын машин нийтдээ 604 ширхэг гэр ахуйн цахилгаан барааг тус үйлдвэрээс хүлээн авч компанийн өөрийн нэрийн дэлгүүр болон хот, хөдөөгийн гэрээт борлуулагчдаар дамжуулан нийт 405 480 900 төгрөгийн борлуулалтыг хийлээ. Монгол дахь гэр ахуйн цахилгаан барааны зах зээлд япон, хятад, малайз улсад үйлдвэрлэгдсэн угаалгын машин зонхилон худалдаалагдаж байгаатай холбогдуулан бид ОХУ-ын угаалгын машиныг туршилтын журмаар цөөн ширхэгийг захиалж борлуулсан. Тус угаалгын машин нь худалдан авагч, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн учраас маш хурдан хугацаанд худалдаалагдаж дууссан нь цаашид бидэнд шинэ бүтээгдэхүүнийг монголын зах зээлд нэвтрүүлэх, худалдан авагчдын эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн бараа бүтээгдэхүүнийг захиалах шаардлагатай байгааг харуулсан ажил болсон. 2014 оны гэр ахуйн цахилгаан барааны нийт татан авалтын дүнг урьд оныхтой буюу 2013 оныхтой харьцуулан үзэхэд 4%-иар өссөн бол борлуулалт 9,5%-тай өссөн дүнтэй гарсан.

➤ **Цемент болон цементийн түүхий эдийг татан авах, цемент борлуулахтай холбогдуулан дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:**

1. Компанийн ТУЗ-ын 2014 оны 03-р сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрээр “Хөтөлийн Цемент Шохой” ТӨХК-иас цементийн түүхий эдийг татан авахад зориулж Хаан банкнаас 2,5 тэрбум төгрөг, Улаанбаатар банкнаас 4 тэрбум төгрөгийн зээлийг тус тус авч цементийн үйл ажиллагаанд зарцуулсан.
2. Монгол банк, Засгийн газрын хамтарсан тогтоолоор барилгын өртгийг өсгөхгүй байх зорилгоор Барилга хот, байгуулалтын яамнаас хэрэгжүүлсэн “Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр”-т 2014 онд дахин хамрагдсан. Энэ хөтөлбөрийн хүрээнд тус яамнаас 20 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг компанид олгох зөвшөөрөл өгсөн. Компани хөтөлбөрийн дагуу олгогдсон зээлийг зориулалтынх нь дагуу компанийн хөрөнгө оруулалттай Эм Жи Эл Цемент ХХК-д цементийн түүхий эдийг нийлүүлэх зорилгоор Хөтөл дэхь Бейзмент ХХК-тай гэрээ байгуулж урьдчилгаа төлбөрт зориулж зарцуулсан.
2014 онд компани дангаараа БНХАУ-аас чанарын шаардлага хангасан үйлдвэрийн цемент худалдан авахад 5 870 417 114 төгрөг, Хөтөл Цемент Шохой ТӨХК-иас цементийн түүхий эд, цемент худалдан авахад 24 739 992 542 төгрөг нийт 30 610 409 656 төгрөг зарцуулсан.
3. Компанийн охин компани болох “Хантеч” ХХК нь Хөтөл Цемент Шохой ХК-иас компанитай байгуулсан гэрээний дагуу 1618 хопер вагоныг хүлээн авч нийт 108094 тн цементийг барилгын материалын бетон зуурмагийн үйлдвэрүүдэд өөрийн тээврийн хэрэгслэлээр хүргэн өгч 304 сая төгрөгний цэвэр ашигтай ажиллалаа.
4. 2013 онд компанийн хөрөнгө оруулалтаар байгуулсан Эм Жи Эл Цемент ХХК-ийг 2014 онд бүрэн хүчин чадлаар нь ажиллуулж М-425, М-525 маркийн чанартай

цемент үйлдвэрлэн гаргахаар зорилт тавьж ажилласны үр дүнд 28000тн чанарын шаардлага хангасан М-425, М-525 маркийн цемент үйлдвэрлэж 4 тэрбум төгрөгний цементийг цемент хэрэглэгч аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүст нийлүүлж борлуулалт хийлээ.

➤ **Мотоцикл болон мотоциклийн сэлбэг хэрэгслэлийг татан авах, борлуулах, гэрээ хэлцэл байгуулах, төлбөр тооцооны асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан дараахь ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:**

1. 2014 онд БНХАУ-ын мотоциклын “Шинрей” үйлдвэрээс нийт 5 удаагийн татан авалтаар **10000** ширхэг мотоцикл импортолж **13** тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн. 2014 оны мотоциклийн борлуулалтыг өмнөх оны борлуулалттай харьцуулж үзэхэд борлуулалт буурсан явдал нь валютын ханшны зөрүүгээр мотоциклийн үнэ нэмэгдсэнээр энэ нь хүмүүсийн худалдан авах чадварт нөлөөлсөнтэй холбоотой юм. Дээрх хүчин зүйлтэй холбоотойгоор мотоциклийн борлуулалт буурсан ч мотоциклийн борлуулалтыг нэмэгдүүлэх, хэрэглэгч, худалдан авагчдад таниулах, сурталчлах ажлыг 2014 онд Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Ховд зэрэг аймгуудад шинээр хийснээр энэ ажлын үр дүнд 539 сая төгрөгний борлуулалтыг хийлээ.
2. 2014 онд БНХАУ-ын “Шинрей” үйлдвэрээс монголын нөхцөл байдал, монголын худалдан авагчдын хэрэгцээ, шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн-мотоциклийг байнга нийлүүлэх, бүтээгдэхүүний чанар, эдэлгээ, загвар, аюулгүй байдалд байнга анхаарч бүтээгдэхүүнийг шинэчлэн сайжруулж нийлүүлж байх чиглэлээр үйлдвэрлэгч компанитай хамтран ажиллаж энэ талаар мотоцикл нийлүүлэгч үйлдвэр, компанийн холбогдох албаны удирдлага, ажилтнуудтай санал, хүсэлтээ харилцан солилцож уулзалт, яриагаар хэлэлцсэн асуудлуудыг бодит ажил хэрэг болгож ажиллаж байсны үр дүнд 2014 онд мотоциклийн сав, баглаа, боодол, мотоциклийн зарим эд анги сайжирч улмаар 2015 онд нийт “Yingang” мотоциклын үйлдвэрээс шинэ загварын 3 мотоцикл, “Shineray” мотоциклийн үйлдвэрээс шинэ загварын 2 мотоциклыг тус тус монголын зах зээлд нийлүүлэхээр болсон нь 2014 оны мотоциклийн чиглэлээр хэрэгжүүлж гүйцэтгэсэн ажлын амжилт болсон.

2014 онд компани дээрх үндсэн үйл ажиллагаануудаас гадна компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, компанийн ашиг орлогыг нэмэгдүүлэх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийн эрэлт хүсэлт, хэрэгцээ, шаардлагад үндэслэн шинэ төрлийн бизнесийн үйл ажиллагаа явуулахаар холбогдох судалгааг явуулж тус судалгааны үр дүнд туршилтын журмаар БНД-90/130 маркийн замын битумыг ОХУ-аас импортлон худалдаалсан нь маш амжилттай болж ирээдүйтэй бизнесийн эхлэлийг тавьсан. Энэ чиглэлээр 2014 онд 2 тэрбум 500 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Иймд 2015 онд энэ чиглэлээрх судалгаа, шинжилгээний ажлуудыг үргэлжлүүлэн хийж үр дүнд хүргэх зорилт тавин ажиллаж байна.

- 2014 онд компани дээрх үндсэн болон нэмэлт үйл ажиллагаануудаас гадна компанийн ажилтныг компанид тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах зорилгоор компанийн ажилтнуудын нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд ихээхэн анхаарч ажиллалаа. Энэ чиглэлээр жил бүр компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа үйл ажиллагаанаас олсон цэвэр ашгаас компанийн ажилтан шинээр орон сууц худалдан авах, амины орон сууц, хашаа, байшин барих, худалдан авах, их сургуульд сурах, өндөр өртөгтэй эмчилгээ, сувилгаа хийлгэх тохиолдолд ажилтнаас гаргасан өргөдөл, хүсэлтэд үндэслэн ажлын үр дүн, ахуй амьдралын зайлшгүй нөхцөл байдлыг харгалзан үзэж дээрх чиглэлээр нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд компаниас тусламж, дэмжлэг олгож байхаар **“Нийгмийн хөгжлийн фонд”**-ны журмыг боловсруулж уг журмын төслийг ТУЗ-д хэлэлцүүлэхээр санал оруулсан. Компанийн ТУЗ Гүйцэтгэх удирдлагаас ирүүлсэн хүсэлт, боловсруулсан журмын төслийг хүлээн авч танилцан гишүүдээр хэлэлцүүлсний эцэст жил бүрийн цэвэр ашгийн дүнг харгалзан цэвэр ашгаас тодорхой хувиар компанийн ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд олгож байхаар шийдвэрлэсэн. 2014 оны хувьд ТУЗ-аас татвар төлсний дараахь цэвэр ашгийн 2%-ийг ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулах шийдвэрийг ХЭХ-д оруулахаар санал гаргасан.
- Компанийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэх, компанийн үйл ажиллагааг хариуцлагатай, цаг хугацаанд нь үр дүнтэй явуулах зорилгоор компанийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулж ажиллалаа. Үүнд:

1. Компанийн удирдлагаас 2014 оны 03-р сарын 01-нээс эхлэн 6 хүний бүрэлдэхүүнтэй **“Захирлын зөвлөл”**-ийг байгуулах шийдвэрийг гаргасан. Энэ шийдвэрийн дагуу байгуулагдсан “Захирлын зөвлөл” сар бүр компанийн үйл ажиллагаатай холбоотой асуудлуудаар тогтоосон хугацаанд хуралдаж зөвлөлийн гишүүдийн хамтын шийдвэрээр асуудлыг шийдвэрлүүлдэг болсон нь тухайн хэлэлцэх асуудлыг тал бүрээс нь судлах, оновчтой, үр дүнтэй шийдвэр гаргах, алдаа, эрсдэл гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн үр дүнтэй ажил болсон. 2014 онд компанийн үйл ажиллагаатай холбоотой дараахь асуудлуудыг “Захирлын зөвлөл”-ийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэлээ.

- Компанийн бүтэц, зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэж ХЭХ-аар батлуулах.
- “Захирлын зөвлөл” хуралдах, асуудал хэлэлцэх, шийдвэр гаргах үйл ажиллагааны талаар хэлэлцэж журам боловсруулах
- Компанийн ажилчдын цалингийн асуудлыг хэлэлцэж ажилчдын цалинг тодорхой хувиар нэмэгдүүлэх.
- Ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцсыг сайжруулах, хувцасны нормын хугацааны талаар хэлэлцэж чанар, өнгө, үзэмж сайтай ажлын хувцсыг ажилчдад олгох, оффисийн ажилтнуудын ажлын хувцасны загвар, хийц, материалын талаар судалгаа явуулах, ажлын дүрэмт хувцастай болгох.

- Төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн ажлын биелэлт, компанийн үйл ажиллагаанд гарч байгаа бэрхшээлтэй асуудлуудын талаар хэлэлцэж холбогдох ажилтнуудад үүрэг, даалгавар өгөх
 - 2013, 2014 оны ажлын үр дүн, биелэлтийг харгалзан компанийн ажилчдыг шагнаж урамшуулахаар алба тус бүрээс ирүүлсэн ажилчдын тодорхойлолтыг хэлэлцэж ажилчдад шагнал, урамшууллыг олгох, төрийн байгууллагад ажилтнуудын тодорхойлолтыг хүргүүлэх. /Энэ ажлын үр дүнд компанийн удирдлагаас 2 ажилтныг төрийн одон медальд тодорхойлж тодорхойлолтыг шаардагдах материалын хамт төрийн байгууллагад хүргүүлсэн. 2014 онд компанийн 2 ажилтан **“Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”, “Хөдөлмөрийн хүндэт медаль”**-иар тус тус шагнагдсан.
 - Компанийн “Ахмадын зөвлөл” –тэй хамтран ажиллах талаар хэлэлцэж энэ чиглэлээр журам боловсруулах.
 - Компанийн ажилчдаас болон компанид ажиллаж байгаад тэтгэвэртээ гарсан ахмад ажилтнуудаас тус бүр 1 хүнийг жил бүр шалгаруулж компанийн “Хүндэт дэвтэр”-т нэр алдар, ажил хөдөлмөр, гавьяа бүтээлийг нь алдаршуулж байх асуудлыг хэлэлцэж энэ талаар журам боловсруулж батлуулах.
 - Жил бүрийн зун, өвлийн цагт компанийн нийт ажилчдыг амралтын 1 өдрөөр эрүүл агаарт гаргаж ажилчдын дунд спортын тэмцээн, уралдаан зохион байгуулж явуулдаг уламжлалтай холбогдуулан энэ үйл ажиллагааг 2014 онд зохион байгуулах, зарцуулах мөнгөн хөрөнгийн асуудлыг хэлэлцэх
 - Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар хэлэлцэж тусгай журам боловсруулж ТУЗ-д санал оруулж хэлэлцүүлж батлуулах асуудлуудыг тус тус хэлэлцэж шийдвэр гаргаж хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллалаа.
1. Компанийн ажилчдын болон Түрээслэгчдийн ая тухтай орчинд ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, байгалийн хүчин зүйлсийн нөлөөллөөр хуучирч өнгө нь гандсан компанийн барилгын гаднахь өнгө үзэмжийг сэргээн засварлах, ашиглалтын хугацааг уртасгах зорилгоор компанийн барилгын дотор болон гадна хэсэгт барилгын иж бүрэн засвар үйлчилгээг дараахь компаниудтай гэрээ байгуулж хийж гүйцэтгүүлэн биелэлтэнд нь хяналт тавьж ажиллалаа . Үүнд:
 1. “ Экструд констракшн” ХХК-тай 46 675 720 төгрөгийн “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулж компанийн барилгын гадна талын фасадыг стандартын дагуу будах ажлыг гүйцэтгүүлсэн.
 2. “Бусана” ХХК-тай 338 сая 224 000 төгрөгийн “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулж сүүлийн үеийн засал чимэглэл бүхий барилгын засварын ажлыг хийж гүйцэтгүүлсэн.

- Компанийн үйл ажиллагаатай холбогдуулан дараахь ажлыг хийлгүүлэхээр гадны компанитай гэрээ байгуулж гүйцэтгэл, биелэлтэнд нь тус тус хяналт тавьж ажиллалаа. Үүнд:
 3. “Дек” ХХК-тай 100 000 000 төгрөгийн “ Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулж компанийн зам, талбайг 20мм-ийн зузаантай бетондох ажлыг хийж гүйцэтгүүлсэн.
- 2014 оны 5 сарын 09-нд Барилга, хот байгуулалтын яамнаас компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагааг өндрөөр үнэлж компанид “**Татварын албаны дээд шагнал**” цом, гэрчилгээг гардуулсан. Энэ бол компанийн ажлын үр дүнг төрийн байгууллагаас үнэлсэн томоохон үйл явдал болсон.
- 2013 онд Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй компаниудаас явуулж буй үйл ажиллагаануудынх нь үр дүнг үндэслэн МҮХАҮТ-аас шалгаруулалт явуулсан. Энэ шалгаруулалтаар компанийн Гүйцэтгэх захирлыг “Хөрөнгө оруулагч” цом, гэрчилгээгээр шагнасан.
- 2014 онд санхүү эдийн засгийн орчин, бараа үйлчилгээний үнэ, валютын ханш, инфляцийн түвшин зэрэг бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд шууд нөлөөлдөг нөхцлүүд сайнгүй байсан боловч компанийн Гүйцэтгэх удирдлага, ажлын хамт олноос идэвх зүтгэл, хүчин чармайлт гаргаж ажилласны үр дүнд бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөө 80%-ийн биелэлттэй, 2014 оны компанийн санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүд урьд оныхоос өссөн дүнтэй гарч 2015 оныг ажлын амжилтаар угтлаа. Иймд 2014 онд компанийн удирдлагын үйл ажиллагааг үр дүнтэй явуулахад туслалцаа, дэмжлэг үзүүлж хамтран ажилласан компанийн ТУЗ болон гишүүдэд талархлаа илэрхийлье.

2015 оныг ажил, хөдөлмөрийн амжилтаар угтсан ч 2014 оны эдийн засгийн дээр дурдсан таагүй нөхцөл байдал энэ онд үргэлжилсэн хэвээр байна. Цаашид ч эдийн засгийн таагүй байдал үргэлжлэх төлөвтэй байгааг төр засгийн холбогдох байгууллага, мэргэжлийн хүмүүсээс анхааруулга, авах арга хэмжээ, зөвлөмжийг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад хандаж өгсөөр байгааг компанийн хувьцаа эзэмшигч та бүхэнд онцлон хэлмээр байна. 2015 он гарсаар улс оронд нүүрлээд байгаа эдийн засгийн хүндрэл нь компаниас хэрэгжүүлэх аливаа бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлж үйл ажиллагаа явуулахад бэрхшээл учруулж байна. Гэхдээ бид байдал хүнд хэцүү байна гээд хүлээгээд суух биш өөрсдийн хүч бололцоо, давуу байдал, боломжит бүх нөхцөл байдлыг судалж дүн шинжилгээ хийх, ажлын баг, хамт олонтойгоо хэлэлцэж ярилцах, уулзалт, хурлаас гарсан шийдвэрийн биелэлтэнд тогтмол хяналт тавих, ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлсний үндсэн дээр цаашид авч хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох зарчмаар үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнтэй холбогдуулан компанийн удирдлагаас 2015 оныг компанийн хэмжээнд сахилга, хариуцлагыг өндөржүүлж ажиллах жил болгож санхүүгийн аливаа эрэдлээс хамгаалж компанийн ажилтан бүр эрхэлж буй ажилдаа хариуцлагатай хандах, үйл ажиллагаандаа хэмнэлтийн зарчмыг мөрдлөг болгон ажиллаж 2015 оны ажлын төлөвлөгөөг биелүүлж

ажиллах зорилго тавьсан. Компанийн удирдлага 2016 онд хувьцаа эзэмшигч та бүхэнтэйгээ ажлын их амжилтаар дүүрэн дахин уулзана гэдэгт итгэл төгс байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

ХЭХ-ын дарга Т. Тунгалаг: Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын дүгнэлтийг компанийн Аудитын хорооны тайлангийн хамт ТУЗ-ын аудитын хорооны дарга, хараат бус гишүүн Ж. Баярсайхан танилцуулна.

Ж.Баярсайхан: Сайн байцгаана уу Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид ээ. 2014 оны ХЭХ-аар батлагдсан Техник импорт ХК-ийн 2014 оны үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг биелүүлэхэд валютын ханшны өсөлт сөргөөр нөлөөлсөн боловч компанийн удирдлага, хамт олон хүч бололцоогоо бүрэн дүүрэн ашиглаж ТУЗ-аас өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлж сайн ажилласан гэдгийг тэмдэглэж байна. Энэ бүхнийг гүйцэтгэх захирлын тайлангаас та бүхнийг анзаарч ойлгосон байх гэдэгт итгэж байна. Техник импорт ХК-ийн ТУЗ-ын хурлаар компанийн 2014 оны санхүүгийн тайлан түүнд хийсэн аудитын дүгнэлтийн талаар хэлэлцэж ТУЗ-аас гаргасан дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчид та бүхэнд танилцуулья.

Тус компани нь 2014 оны Санхүүгийн жилд үндсэн үйл ажиллагаанаас 41 тэрбум 13,6 сая төгрөгийн орлого олсон нь урьд оноос 14 тэрбум 488,5 сая төгрөгөөр буюу 54,6 хувиар өссөн байна. Харин борлуулсан бүтээгдэхүүний өртөг урьд жилээс 57,6 хувиар өссөн нь борлуулалтын хэмжээ ихээхэн хэмжээгээр өссөн буюу гадаад валютын ханшийн өсөлтөөс шууд хамаарч байна. Борлуулалтаас олсон ашиг 3 тэрбум 285,9 сая төгрөг болж өмнөх оноос 689,7 сая төгрөгөөр буюу 26,5 хувиар өссөн байна. Харин үндсэн бус үйл ажиллагааны орлого 675,1 сая төгрөгт хүрч урьд оны түвшинд байна. Харин гадаад валютын ханшийн алдагдал 9 сая 722000 төгрөгт хүрчээ.

Үндсэн үйл ажиллагааны зардал 2 тэрбум 334,4 сая төгрөгт хүрч урьд оноос 202,3 сая төгрөгөөр өссөн байна. Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал буурсан байна. Татвар төлөхийн өмнөх ашиг 1 тэрбум 519,7 сая төгрөг болж урьд оноос 385,4 төгрөгөөр өссөн. Улсын төсөвт аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 151,9 сая төгрөг төлөхөөр ногдуулж тайлант үеийн цэвэр ашиг 1 тэрбум 367, 7 сая төгрөг болж урьд оноос 347,8 сая төгрөгөөр өссөн байна.

2014 онд улсын төсөвт тус компани 5 тэрбум 445,6 сая төгрөгийн татвар шимтгэл төлжээ. Үүнд:

- ААНОА татварт - 152,1 сая төгрөг
- НӨАТатварт - 4 тэрбум 177 сая төгрөг
- Гаалийн татварт- - 1 тэрбум 3,8 сая төгрөг
- НДШимтгэлд- - 102,9 сая төгрөг
- Бусад татварт - 9,8 сая төгрөг төлсөн байна.

Эргэлтийн хөрөнгө оны эцэст 28 тэрбум 273 сая төгрөг байна. Үүнд: мөнгөн хөрөнгө 491,9 сая төгрөг, бараа материал 3 тэрбум 334,1 сая төгрөг, авлага 24 тэрбум 426,3 сая төгрөг байна.

Авлага урьд оноос 17 тэрбум 976,4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө 3 тэрбум 426,5 сая төгрөгт хүрсэн байна.

Дансны өглөг урьд оноос 1 тэрбум 104,9 сая төгрөгөөр нэмэгдэж 2 тэрбум 926,2 сая төгрөгт хүрчээ. Банкны богино хугацаатай зээлийн өглөг 20 тэрбум 709,3 сая төгрөг байна.

Хуримтлагдсан ашиг оны эцэст 6 тэрбум 300,6 сая төгрөг байна.

Тус компаний 2013 оны Санхүүгийн тайлангийн дүнгээс үзэхэд компанийн цэвэр хөрөнгө / 31 тэрбум 699,6 (нийт хөрөнгө)- 24 тэрбум 573,4 сая төгрөг (өр төлбөр)/ – 7 тэрбум 126,2 сая төгрөг байна.

Эргэлтийн хөрөнгөөрөө өр төлбөрөө төлөх боломж /28 тэрбум 273,1 сая төгрөг (эргэлтийн хөрөнгө)- 24тэрбум 573,4 сая төгрөг /өр төлбөр/ = 3 тэрбум 699,7 сая төгрөг болж байгаа нь төлбөрийн чадвар бүрэн боломжтой байгааг харуулж байна.

Цаашид анхаарах зүйл:

- Үндсэн бараа материалын нөөцийг борлуулж эргэлтэнд оруулж мөнгөн хөрөнгийн эргэлтийг нэмэгдүүлэх.
- Дансны авлагыг нэг бүрчлэн судалж, түүнийг шуурхай барагдуулах ажлыг зохион байгуулах.

Дээрхи ажлуудыг зохион байгуулж хэрэгжүүлснээр мөнгөн хөрөнгийн эргэлт нэмэгдэж, улмаар банкны богино хугацаатай зээлийн хэмжээг бууруулснаар хүүгийн зардал багасч компанийн ашиг орлого нэмэгдэх бүрэн боломжтой байна гэсэн дүгнэлтийг компанийн ТУЗ-аас гаргасан.

- ТУЗ-ын Аудитын хороо нь компанийн дотоод аудитын албанд МУ-ын хууль тогтоомжийн дагуу компанийн санхүүгийн болоод бусад үйл ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар тодорхой хугацаанд хийж гүйцэтгэх ажлын чиглэлээр үүрэг даалгавар өгч ажлын биелэлтийг шалгах, хяналт тавих, дүн шинжилгээ хийх, үйл ажиллагаанд гарч байгаа зөрчил дутагдлыг арилгуулах, анхааруулах, зөвлөмж өгөх чиглэлээр ажиллаж ирлээ. 2014 онд ТУЗ-ын Аудитын хорооноос компанийн дотоод аудитын албанд доорх чиглэлээр ажлын чиглэл, үүрэг даалгавар өгч биелэлтэнд хяналт тавьж ажиллалаа. Үүнд:

1. 2014 онд Дотоод аудитын албанаас сар бүр хийх ажлын төлөвлөгөөг гаргуулах.

2. Компанийн үндсэн хөрөнгө, аж ахуйн хангамжийн материал, цахилгаан бараа, дэлгүүр, мотоцикл, цемент, авто машин, автомашины сэлбэг хэрэгслийн агуулах тус бүрийн тайлан баримтуудыг шалгах, сар бүрийн бараа материалын хөдөлгөөн, орлого, зарлагын баримтын бүрдэлт, эд хариуцагч, нябо нарын үлдэгдлийн баталгаажуулалтыг шалгах.
3. Борлуулсан барааны худалдах үнэ импортоор болон дотоодоос худалдан авсан өөрийн өртгийн тооцоолол үнэн зөв гарсан эсэхийг тооцоолж хянах.
4. Үндсэн хөрөнгө, бараа материалын хагас болон жилийн эцсийн тооллогод биечлэн оролцож тооллогод хяналт тавьж ажиллах.
5. Техникийн захад түрээсээр ажиллуулж байгаа 20 болон 40 тн-ын чингэлэгүүдийн тооллогыг хийх.
6. Конторын түрээс, техникийн захын түрээс, цементийн захын талбайн түрээсийн төлбөр, тооцооны баримтыг шалгах,
7. Бэлэн мөнгөний касс болон арилжааны банкуудад байгаа тооцооны харилцах дансдын тайлан, хуулгыг сар бүрээр авч шалгах.
8. НӨАТ-ын тайланг шалгах.
9. Орон нутагт ажиллаж байгаа гэрээт борлуулагчдад байгаа бараа, материалын тооцоо, үлдэгдлийг шалгах.
10. Компанийн нябо нарын үйл ажиллагаанд хяналт тавих.
11. Компанийн охин компаниудын санхүүгийн баримтанд шалгалт хийх.

Дээрх чиглэлийн дагуу компанийн дотоод аудитын алба дараахь ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. 2014 онд сар бүр хийх ажлын төлөвлөгөөг гаргаж компанийн гүйцэтгэх захирлаар батлуулан дараа сарын 05-ны дотор хийсэн ажлын тайланг Аудитын хороо болон Гүйцэтгэх захиралд танилцуулж ажилласан.
2. Компанийн үндсэн хөрөнгө, аж ахуй хангамжийн материал, цахилгаан бараа, дэлгүүр, мотоцикл, цемент, авто машин, автомашины сэлбэг хэрэгслийн агуулах тус бүрийн тайлан баримтуудыг сар бүр, сар бүрийн бараа материалын хөдөлгөөн, орлого, зарлагын баримтын бүрдэлт, эд хариуцагч, нябо нарын үлдэгдлийн баталгаажуулалтыг улирал, жилээр шалгаж ажилласан .
3. Агуулах тус бүрээр тухайн бараа, материалын борлуулалтаас үүссэн авлагыг сар бүрийн эцсийн байдлаар байгууллага, хувь хүн тус бүрээр гаргаж авлагыг шуурхай барагдуулах талаар хариуцсан нябо, менежер нарт мэдэгдэл өгч ажилласан.
4. Компанийн автомашины ашиглалт, жолооч нарын хэрэглэж байгаа түлш шатахууны тооцоог сар бүр хүлээн авч жолооч тус бүрээр гүйцэтгэсэн ажил, замын хуудас, явсан км-ыг шатахуун зарцуулалтын нормоор шалгаж тооцооны үлдэгдлийг шалгаж хэвшүүлсэн.

5. Компанийн охин компани болох Ти Ай Ложистик ХХК, Эм Жэй Партнерс ХХК, Хангеч ХХК-иудын санхүүгийн баримтыг хагас болон жилээр нь авч шалгасан. Шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг нэг бүрчлэн бичиж холбогдох ажилтанд хэлж танилцуулсны дагуу зөрчлийг арилгах үүрэг даалгавар өгөх, дутуу баримтыг гүйцээж бүрдүүлэн ажилласан.

ТУЗ-ын Аудитын хороо дотоод аудитын албатай хамтран ажилласны үр дүнд компанийн нябо нарын сар бүрийн тайлан гаргалт цаг хугацаандаа гарч хэвшсэний зэрэгцээ санхүүгийн холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагуудыг тогтмол мөрдөж ажиллах нөхцөл бүрдэж санхүүгийн баримт бичгийн бүрдүүлэлт сайжирч зөрчил, дутагдал гарах нь багасч компанийн аливаа үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явах тогтолцоог бий болгож ажиллалаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Хурлын дарга Т. Тунгалаг: 2014 оны ТУЗ-ын төсвийн гүйцэтгэл, 2015 оны ТУЗ-ын төсвийн талаар ТУЗ-ын нарийн бичгийн дарга О. Бүжинлхам танилцуулна.

О. Бүжинлхам: Сайн байцгаана уу. Хувьцаа эзэмшигчид та бүхэнд энэ өдрийн мэнд хүргье. 2014 онд ТУЗ-ын төсвөөс зарцуулсан хурлын болон бусад зардлын тайланг та бүхэндээ танилцуулья. Компанийн 2014 оны ХЭХ-аар ТУЗ-ын төсвийг 23 200 000 төгрөгөөр баталсан. 2014 онд ТУЗ-ын хурал ногдол ашиг олгох, ХЭХ-ыг зарлан хуралдуулах, банкнаас зээл авах зэрэг хуульд заасан болон компанийн үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн асуудлуудаар нийтдээ 5 удаа хуралдаж шийдвэр гаргасан. ТУЗ-аар хэлэлцсэн асуудлуудын 3 нь компанийн үйл ажиллагаатай холбогдуулан Гүйцэтгэх удирдлагаас ирүүлсэн саналтай холбоотой асуудал байсан ба ТУЗ-ын гишүүдийн 100%-ийн зөвшөөрлийн саналаар ТУЗ-аас Гүйцэтгэх удирдлагын саналын дагуу Гүйцэтгэх захиралд эрх олгож шийдвэрлэсэн байна.

ТУЗ-ын төсвийн зарцуулалтыг ангилж үзэхэд:

1. ТУЗ-ын хурал / 3 650 000 /
2. ТУЗ-ын гишүүдийн томилолт / 4 000 000 /
3. ҮЦТТТХТ-аас хувьцаа эзэмшигчдийн жагсаалт авах / 63 113 /
4. ҮЦТТТХТ-тэй гэрээ байгуулах / 150 000 / тус тус зарцуулагдсан байна.

Дээрх зарцуулалтын дүнг нэгтгэн үзвэл 2014 оны ХЭХ-аар батлагдсан нийт ТУЗ-ын төсвөөс 2014 оны ТУЗ-ын үйл ажиллагаанд нийт 7 863 113 төгрөг зарцуулагдсан байна. Хувьцаа эзэмшигч та бүхэн 2015 оны ТУЗ-ын төсөвтэй танилцана уу.

ХЭХ-ын дарга Т.Тунгалаг: ТУЗ-ын Аудитын хорооны дарга Ж. Баярсайхан ТУЗ-аас ногдол ашгийн талаар хэлэлцэж гаргасан шийдвэрийг та бүхэнд танилцуулна.

ТУЗ-ын Аудитын хорооны дарга Ж. Баярсайхан: ТУЗ-ын гишүүд компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд аудитаас хийсэн дүгнэлтийг үндэслэн 2015 онд ногдол ашиг олгох эсэх талаар хэлэлцэж шийдвэр гаргасан. 2014 оны нэгж хувьцаанд 300 төгрөг байхаар тооцож ногдол ашгийг хуваарилж олгохоор шийдвэрлэсэн. Энэ тухай шийдвэрийг Хөрөнгийн бирж болон СЗХ-нд албан ёсоор хүргүүлсэн. Хувьцаа эзэмшигч та бүхэнд өмнөх онд олгосон ногдол ашгийн тайлангийн талаар танилцуулья. 2014 онд 2013 оны ногдол ашгийг компаниас олгосон. Ногдол ашиг олгосон тайлангаас харахад нийт ногдол ашгийн 99%-ийг компанийн хувьцаа эзэмшигчдэд олгосон дүнтэй байна.

Компанийн нийт борлуулалтын орлогыг өмнөх онуудынхтай харьцуулж үзэхэд:

- 2012 онд 24 тэрбум 208, 646,6
- 2013 онд 26 тэрбум 525, 133 байсан бол 2014 онд 41 тэрбум 13,6 сая төгрөг болж орлого өссөн нь урьд оноос 14 тэрбум 488,5 сая төгрөгөөр буюу 54,6 хувиар өссөн байна.

Борлуулалтаас олсон ашиг

- 2012 онд 3 тэрбум 178,288,1
- 2013 онд 2 тэрбум 596, 187,8₮ байсан бол 2014 онд 3 тэрбум 285,9 сая төгрөг болж өмнөх оноос 689,7 сая төгрөгөөр буюу 26,5 хувиар өссөн байна.

Татвар төлөхийн өмнөх цэвэр ашиг 2012 онд 1 тэрбум 774, 882₮
2013 онд 1 тэрбум 134, 353,629₮ байсан бол 2014 онд тайлант үеийн цэвэр ашиг 1 тэрбум 367, 7 сая төгрөг болж өссөн байна.

Татварын дараахь цэвэр ашиг 2012 онд 1 тэрбум 597,393,1
2013 онд 1 тэрбум 019 901 600 төгрөг байсан бол 2014 онд 1 тэрбум 367 763 000 болсон байна.

Иймд дээрх үзүүлэлтүүдийг харгалзан үзэж нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийг 300 төгрөг байхаар хуваарилан олгох саналтай байгаа юм.

ХЭХ-ын дарга Т. Тунгалаг: Дараагийн хэлэлцэх асуудалдаа орьё. Хувьцаа эзэмшигчид та бүхнээр хэлэлцүүлж батлуулахаар “2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Нийгмийн хөгжлийн фонд”, “Компанийн бүтэц, зохион байгуулалт”-ын төслүүдийн талаар танилцуулья.

Журмын хувьд компанийн удирдлагаас борлуулалтын ашгийн тодорхой хувийг ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зориулж зарцуулж байх саналыг ТУЗ-д ирүүлсэн. Гүйцэтгэх удирдлагаас ирүүлсэн саналын дагуу ТУЗ хуралдаж асуудлыг

боловсруулж ирүүлсэн журмын хамт хэлэлцээд жил бүр цэвэр ашгийн дүнг харгалзан тодорхой хувийг ажилчдын нийгмийн асуудалд зарцуулж байх шийдвэрийг гаргасан. Иймд ТУЗ 2014 оны компанийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг хэлэлцээд цэвэр ашгийн 2%-ийг нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зориулж зарцуулах саналыг хувьцаа эзэмшигч та бүхнээр хэлэлцүүлж батлуулах саналтай байна.

Засгийн газраас гаргасан 2011 оны 11-р сарын 09-ний өдрийн 311 тоот тогтоолыг үндэслэн компанийн Гүйцэтгэх захирал компанид **“Дотоод аудитын алба”** гэсэн байнгын орон тооны бүтцийг 2012 оноос шинээр бий болгон ажиллуулж байна. Энэхүү албаны гол онцлог нь компанийн бусад албадаас хараат бусаар өөрөөр хэлбэл гүйцэтгэх захирлын удирдлагад шууд захирагдаж зөвхөн санхүүгийн төдийгүй компанийн бүх үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх, үр дүнг сар бүр компанийн захиралд тайлагнах, гарсан үр дүнгийн дагуу авах арга хэмжээ, зөвлөмжийг санал хэлбэрээр Гүйцэтгэх удирдлагад өгдөг алба гэдгээрээ бусад компанийн албадаас онцлогтой. Энэ алба нь байгуулагдсан цагаасаа хойш компанийн үйл ажиллагаанд үр дүнгээ өгч байгааг онцлон хэлмээр байна. Аливаа байгууллага, аж ахуйн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаа хэр цэгцтэй, дэг журамтай, хууль, дүрмийн дагуу явж байгаа эсэхээс хамааран тухайн компанийн бусад үйл ажиллагаа ямар байх нь шууд хамаардаг. Үүний илрэл нь сүүлийн жилүүдэд компанийн санхүүгийн үйл ажиллагаа зөрчил, дутагдалгүй явагдах, үйл ажиллагаа өргөжин тэлэх, санхүүгийн үзүүлэлтүүд өссөн дүнтэй гарах, санхүүгийн чадавхыг сайжруулах нөхцлийг бүрдүүлэхэд энэ алба ихээхэн ач холбогдлоо өгч байгаа. 2014 онд Сангийн яамнаас компанийг “Татварын албаны дээд шагнал” цом, гэрчилгээгээр шагнасан нь ТУЗ-ын аудитын хороо албанд зөвлөмж, чиг үүрэг өгч, түүний биелэлт, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг нь хэлэлцэх, шаардлагатай нөхцөлд мэргэшсэн зөвлөмж, зөвлөгөөг өгөх, албанаас чиг үүргийн дагуу ажиллаж өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлж хороонд тайлагнах зэргээр ажил хэргийн байнгын харилцан уялдаа холбоотой, хамтран ажилласнаар компанийн санхүүгийн төдийгүй бусад үйл ажиллагаа сайжрахад үр дүнгээ өгч байгааг харуулсан, нотолсон үйл явдал болсон гэж ТУЗ-ын даргын хувьд дүгнэж байгаа.

2014 онд компанийн бүтцэд орсон томоохон өөрчлөлт бол компанийн удирдлага “Захирлын зөвлөл”-ийг байгуулж ажиллуулсан. Та бүхэнд компанийн “Захирлын зөвлөл”-өөр хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлуудын талаар компанийн удирдлагаас танилцуулсан үйл ажиллагааны тайланд тодорхой дурдаж мэдээллийг өгсөн тул дахин та бүхэнд танилцуулах шаардлагагүй байхаа гэж үзэж байна. Иймд эдгээр нөхцөл байдалтай холбогдуулан компанийн бүтцэд орсон өөрчлөлтүүдийг тусгасан компанийн шинэ бүтцийг хувьцаа эзэмшигч та бүхнээр батлуулах саналтай байна.

ТУЗ 2014 оны компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцээд төлөвлөгөөг 80%-ийн биелэлттэй гэж дүгнэсэн. 2014 онд төлөвлөгөө биелүүлэхэд улс орны эдийн засгийн таагүй байдал, валютын ханшны өсөлт нь ихээхэн сөргөөр нөлөөлсөн гол хүчин зүйл болсон. Энэ нь үйл ажиллагааны үр дүнгээс харагдсан. Хэдийгээр биелэлт 80%-тай дүгнэгдсэн ч 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг өсгөж батлуулах саналтай байна.

Үүнээс гадна өөр нэг чухал асуудал бол ТУЗ-ын гишүүдийн талаарх саналаа хэлэхийг хүсч байна. Компанийн дүрэмд “ТУЗ-ын гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 1 жил буюу дараагийн ХЭХ хүртэл 1 жилийн хугацаагаар ажиллуулна” гэж заасан. Компанийн дүрмийн энэ заалтын дагуу ТУЗ-аас 2015 оны ХЭХ-д ТУЗ-ын гишүүдийг дахин сонгож томилох асуудлыг оруулах ёстой байсан. Гэхдээ ТУЗ-аас болон ТУЗ-ын гишүүдээс хийж хэрэгжүүлсэн ажил, үйл ажиллагааны тайланг хэлэлцэж дүгнээд 2015 онд ТУЗ-ыг

одоогийн байгаа гишүүдийнх нь бүрэлдэхүүнтэй ажиллуулах нь зүйтэй юм гэсэн шийдвэрийг гаргасан. Энэ шийдвэр нь нэг талаас Дүрмээ зөрчиж байгаа юм шиг боловч нөгөө талаас ТУЗ-ын гишүүд компанийн удирдлагын хамтарсан үйл ажиллагааны үр дүнд компанийн санхүүгийн болон удирдлагын үйл ажиллагаа жилээс жилд сайжирч түүнд гарч байгаа өөрчлөлт, үр дүнтэй уялдуулан гаргасан шийдвэр юм. Хувьцаа эзэмшигч та бүхнийг компанийн үйл ажиллагаанд гарч байгаа өөрчлөлт, үр дүнгийн үзүүлэлтүүдийг ТУЗ-ын аудитын хорооны дарга болон компанийн удирдлагаас танилцуулсан санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангаас ойлгож авсан байгаа гэж бодож байна. Та бүхэнд 2015 оны ХЭХ-аар хэлэлцэх асуудлууд болон ТУЗ-аас гаргасан саналуудыг ТУЗ-ын Аудитын хорооны дарга, гүйцэтгэх удирдлагаас танилцуулж дууслаа. Хувьцаа эзэмшигч та бүхнийг хэлэлцэх асуудалтай холбогдуулан санал, хүсэлтээ хэлэхийг хүсч байна.

Хувьцаа эзэмшигч Д.Ганхуяг: ТУЗ-аас гаргасан шийдвэртэй санал нэг байна. Компанийн удирдлагаас хэрэгжүүлсэн ажлууд болон ТУЗ-аас гаргасан ногдол ашгийн талаарх тайланг сонслоо. Дэмжиж байна.

Хувьцаа эзэмшигч Г.Содбилэг: Нэгж хувьцаанд олгох ногдол ашгийн хэмжээ 300 байхыг дэмжиж байна. Гүйцэтгэх захирлын тайланг сонслоо. ТУЗ болон компанийн удирдлагад хувьцаа эзэмшигчид, ажилчдынхаа төлөө тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд санаа тавьж ажиллаж байгаад талархлаа илэрхийлье. Та бүхэнд 2015 онд ажлын амжилт хүсье.

Хувьцаа эзэмшигч Л. Оюун: ТУЗ-ын саналыг дэмжиж байна. Гүйцэтгэх удирдлагын тайлантай танилцлаа. Компанийн үйл ажиллагаа сайн явагдаж байгаа юм байна. Компанид оруулсан бүтцийн өөрчлөлтийг бүрэн дэмжиж байна. Энэ бол компанийн үүрэг, хариуцлагыг улам бүр сайжруулахад чухал алхам болсон зүйл байна. Компанийн үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байна.

Д. Ганбат: Сүүлийн жилүүдэд улс орны эдийн засгийн байдал муудаж үйл ажиллагаа явуулахад хүндрэл, бэрхшээл учруулж байгаа нь зөвхөн аж ахуйн нэгж, байгууллагын хүрээнд төдийгүй жирийн иргэдийн амьдралд ч нөлөөлж байгаа нь анзаарагдаж байгаа. Ийм хэцүү үед компанийн үйл ажиллагааг удирдаж авч явах хэцүү ч хүнд нөхцөлд компанийн үйл ажиллагааг амжилттай авч яваа компанийн удирдлагад талархлаа илэрхийлэхийг хүсч байна. 2014 онд компанийн удирдлагаас компанид нэлээн ажлыг хийж хэрэгжүүлсэн байна. Энэхүү хурлаар хэлэлцэгдэж байгаа асуудал, саналуудыг дэмжиж байна. Батлах саналтай байна.

Хурлын дарга Т. Тунгалаг: Өөр саналаа хэлэх хүн байна уу? Гараа өргөнө үү? За санал, шүүмжлэл байхгүй бол санал хураалтыг явуулья. Хурлын тооллогын комисс-т хэлэлцсэн асуудал бүрээр санал хураалт явуулж дүнг танилцуулахыг хүсэж байна.

Тооллогын комиссын дарга Б. Лхамсүрэн: 2015 оны 03-р сарын 16-ны өдрийн ХЭХ-аар:

1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан түүнд хийсэн аудитын талаар ТУЗ-аас гаргасан дүгнэлт
2. Компанийн 2015 оны ажлын төлөвлөгөө
3. Компанийн Аудитын хорооны тайлан
4. Компанийн дотоод бүтэц, зохион байгуулалт
5. 2014 оны ногдол ашгийн хуваарилалтын талаар ТУЗ-аас гаргасан шийдвэр

6. 2014 оны ногдол ашиг хуваарилалтын талаар ТУЗ-аас гаргасан шийдвэрийг үндэслэн компанийн цэвэр ашгийн 2%-ийг ажилчдын нийгмийн асуудалд зориулж зарцуулах
7. 2015 оны ТУЗ-ын төсөв

хэлэлцсэн асуудлаар тус тус санал хураалт явуулж саналын хуудсуудыг тоолоход нийт хувьцаа эзэмшигчид 100 %-ийн саналаар дэмжсэн байна.

Хурлын дарга Т. Тунгалаг: Эрхэм хувьцаа эзэмшигчид ээ. Та бүхэнд санал хураалтын дүнг танилцуулья. Хурлаар хэлэлцсэн асуудлыг та бүхэн 100 %-ын саналаар дэмжсэн байна. Татгалзсан, түтгэлзсэн санал өгсөн хуудас тоологдоогүй байна. Хүчингүй хуудас гараагүй байна. Ингээд төслийн шийдвэрийн дагуу тогтоолыг батлах шийдвэрийг өнөөдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргаж байна. /ХЭХ-аас гаргасан тогтоолуудын төслийг хувьцаа эзэмшигчдэд уншиж танилцуулав. /

Манай өнөөдрийн ХЭХ амжилттай болж өндөрлөлөө. Хувьцаа эзэмшигч та бүхэнд ажлын амжилт, эрүүл энх, хамгийн сайн сайхан бүхнийг хүсье. Ингээд 2015 оны ээлжит ХЭХ хаасныг мэдэгдье. Та бүхэнд баярлалаа.

11 цаг 20 минутанд дуусав.

Тэмдэглэл хөтөлсөн:

О. Бүжинлхам

О. Бүжинлхам

ХУРЛЫН ДАРГА



Т. Тунгалаг

Т. Тунгалаг